

Монгол Улсын хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн төлөв байдал, хандлага

Эрдэнэ-Очирын Энхмаа

Доктор (Ph.D), дэд профессор, ахлах шинжээч, enkhmaa@iss.gov.mn

Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Стратеги судалгааны хүрээлэн

Хураангуй

Монгол Улсад сүүлийн дөрвөн жилд сэтгэцийн эмгэгийн F00-F99 оношоор амбулаторийн болон стационарийн тусламж, үйлчилгээ авсан эмчлүүлэгчдийн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн судалгааны үр дүнг энэхүү өгүүлэлд толилуулж байна. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг 2022-2024 онд нийт 79861 иргэн 347674 удаа авсан нь жилд дунджаар 26620 хүн, 115891 тохиолдол байсан бол 2025 онд 27908 хүн, 120355 тохиолдол болж өсжээ.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээг 2025 онд авсан 27908 эмчлүүлэгчийг оношийн давтамжаар эрэмбэлж, ангилбал архины шалтгаант эмгэг (F10) хамгийн их байв. Үүний дараа Тархины гэмтэл ба үйл ажиллагааны хямрал, бие махбодын өвчний шалтгаант сэтгэцийн бусад эмгэг (F06), Мэдрэл сульдал (F48), Оюуны хөнгөн хомсдол (F70), Оюуны хүндэвтэр хомсдол (F71), Бие хүний органик эмгэг, энцефалит болон тархины доргилтын дараах хамшинж (F07), Шизофрени (F20), Органик бус нойргүйдэл (F51), Шизоаффектив эмгэг (F25), Стрессийн болон дасан зохицохын эмгэг (F43) тус тус бичигдэж байна. Харин Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн гүйцэтгэсэн “Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалт” сэдэвт судалгаагаар Монгол Улсын 18-64 насны хүн амын дунд сэтгэл түгших эмгэг 18.4, органик бус нойрны эмгэг 17.5, архаг ядаргаа 16.2, тайлбарлаж боломгүй биеийн зовуурь шаналгаа 11.9, архинд донтох эмгэг 6.4, сэтгэл гутрах эмгэг 6.2 хувийн тархалттай байгааг тогтоожээ.

Түлхүүр үгс: Сэтгэцийн эмгэг, архинд донтолт, мэдрэл сульдал, нойргүйдэл, оюуны хомсдол

Нэг. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай ерөнхий ойлголт, эмгэг сэтгэцийн ангилал

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Үндсэн хуульд “Эрүүл мэнд гэдэг нь өвчин эмгэггүй байх төдийгүй бие махбод, сэтгэл санаа, нийгмийн хувьд эрүүл, сайхан аж төрөхийг хэлнэ” хэмээн тодорхойлсон байдаг (World Health

Organization 1946). Хүний сэтгэл тайван амгалан, санаа зовох зүйлгүй, сэтгэцийн хувьд эрүүл байх нь бие махбод эрүүл байх онцгой чухал үндэс юм. “Сэтгэц судлал бол нийгмийн эрүүл мэндийн салбарын судлах гол асуудлын нэг бөгөөд хүний эрүүл мэндэд нийгмийн орчин (аж төрөх ёс) 50, сэтгэл зүйн орчин 30, биологийн хүчин зүйл 20 хувь нь тус тус нөлөөлдөг” гэж судлаачдын дүгнэснээс (Эрдэнэбаяр 2012) үзвэл өвчин эмгэгийн 80 хувь нь нийгэм-сэтгэл зүйн шалтгаантай байдаг ажээ. Судлаач, эрдэмтэн Юнг бие хүний сэтгэл зүйг тодорхойлохдоо **сэтгэц** гэдэг нэр томъёог анх хэрэглэсэн ба сэтгэц нь хүний оюун ухаан, зан үйлийн нарийн төвөгтэй харилцаа холбоог хадгалж байдаг маш өвөрмөц бүтэц бөгөөд тухайн хүнд байдаг бэрхшээлийг даван туулах чадвар алдагдаж бие махбодын, сэтгэл зүйн болон нийгмийн хэрэгцээг зохих ёсоор хангаж чадахгүй болсон үед сэтгэцийн тулгамдсан асуудал буюу хямрал үүсдэг байна (Эрдэнэбаяр 2012). Эндээс үзвэл аливаа хүний сэтгэлийн тэнхээ, сэтгэл хөдлөлөө удирдах чадвар бол сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах үндэс суурь болдог аж.

Өвчний олон улсын Х ангилалд¹ сэтгэцийн бүхий л төрлийн эмгэгийг F00-F99 интервалд кодолж, “Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг” гэсэн бүлгийн ерөнхий нэршил оноосон бөгөөд энэ бүлэг дараах 11 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Сэтгэцийн органик ба шинж тэмдгийн эмгэг (F00-F09);
2. Сэтгэц нөлөөт эм, бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэгүүд (F10-F19);
3. Шизофрени, шизофренийн хэв шинжит ба дэмийрэх эмгэгүүд (F20-F29);
4. Сэтгэл санааны [цочирдлын] эмгэгүүд (F30-F39);
5. Стресстэй холбоотой, неврозын болон биеийн хэлбэрийн эмгэгүүд (F40-F48);
6. Физиологийн хямрал ба биеийн хүчин зүйлстэй холбоотой зан төрхийн хамшинжүүд (F50-F59);
7. Насанд хүрэгчдийн бие хүний ба зан төрхийн эмгэгүүд (F60-F69);
8. Оюуны хомсдол (F70-F79);
9. Сэтгэлзүйн хөгжлийн эмгэг (F80-F89);
10. Хүүхэд ба өсвөр насанд эхлэх зан төрхийн болон сэтгэл хөдлөлийн эмгэгүүд (F90-F98);
11. Сэтгэцийн тодорхойгүй эмгэг (F99).

“Сэтгэцийн эрүүл мэнд” гэдэг ухагдахуунд эрүүл сэтгэц, сэтгэцийн тулгамдсан асуудал, сэтгэцийн эмгэг гэсэн үндсэн гурван ойлголт багтдаг (Баярмаа 2017) бөгөөд эрүүл, эмгэгийн зааг буюу сэтгэцийн хямралын үеийг танин барьж, цаг алдалгүй, оновчтой тусламж, дэмжлэг үзүүлдэг байх нь нийгмийн сэтгэл зүйг эмгэгшихээс хамгаалах асар их ач холбогдолтой.

¹ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас баталсан олон улсын ангиллын энэхүү системийг Монгол Улс 1996 оноос нэвтрүүлж, хүн амынхаа өвчлөл, нас баралтын статистик мэдээллийг гаргадаг болсон.

Хоёр. Монгол Улсын хүн ам дахь сэтгэцийн эмгэгийн тархалт

2.1. Сэтгэцийн ба зан төрхийн эмгэгийн ерөнхий тархалт

Сэтгэцийн эмгэгийн F00-F99 оношоор сүүлийн дөрвөн жилд амбулаторийн болон стационарийн (хэвтүүлэн эмчлэх) тусламж, үйлчилгээ авсан эмчлүүлэгчдийн мэдээллийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авч, энэхүү судалгааны өгөгдөл болгон ашиглалаа. Сэтгэцийн болон зан төрхийн эмгэгийн улмаас “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж” олгох хугацааг сунгахдаа эмнэлгийн үзлэг, эмчилгээнд хамрагдалтын давтамжийг харгалзан үздэг тул Эрүүл мэндийн даатгалын сан (ЭМДС)-гийн санхүүжилттэй тусламж, үйлчилгээний бүртгэл, мэдээллийг харьцангуй бүрэн гэж үзэх үндэстэй юм.

Монгол Улсад 2022-2025 онд 107769 иргэн сэтгэцийн хүрээний оношоор оношлогдож, нийт 468029 удаагийн тусламж, үйлчилгээ авчээ. Үүнээс 2022-2024 онд нийт 79861 иргэн 347674 удаа эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан нь жилд дунджаар 26620 хүн, 115891 тохиолдол байсан бол 2025 онд 27908 хүн, 120355 тохиолдол болж нэмэгдсэн байна.

F00-F99 хүрээний оношоор сүүлийн дөрвөн жилд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдлын тоо жилээс жилд өссөн үзүүлэлттэй, ЭМДС-гаас төлсөн нийт санхүүжилт 142 тэрбум 252 сая төгрөгт хүрч, 2025 онд зарцуулсан санхүүжилтийг 2022 онтой харьцуулахад 1.5 дахин өсжээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. ЭМДС-гаас зарцуулсан санхүүжилт, 2025

Он	Тохиолдлын тоо	Мөнгөн дүн (төгрөг)
2022	102243	28,863,343,008
2023	119239	33,829,952,539
2024	126192	36,657,527,794
2025	120355	42,901,417,951
Нийт	468029	142,252,241,292


Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдлын тоогоор 2025 онд эхний аравт эрэмбэлэгдсэн эмгэг 98382 удаа буюу нийт тохиолдлын 81.74 хувийг эзэлж байв (Хүснэгт 2). Архинд донтох, мэдрэл сульдал, нойргүйдэх, стрессийн эмгэгийн тархалт өндөр байгаа нь өнөөгийн Монголын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлын шууд тусгал гэж үзэх нь илүү бодитой юм. Монгол хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн одоогийн төлөв нэн хүндэрсэн асуудал болсныг оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдол, ялангуяа аутизмын шалтгаанаар эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдлын тооноос тодорхой харж болно.

Хүснэгт 2. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний давтамж, 2025

Байр	Сэтгэцийн эмгэгийн нэр	Тусламж, үйлчилгээний тохиолдол	
		Тоо	Эзлэх хувь
1	Архины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг (F10)	18048	15.0
2	Мэдрэл сульдал (F48)	17672	14.7
3	Тархины гэмтэл ба үйл ажиллагааны хямрал, бие махбодын өвчний шалтгаант сэтгэцийн бусад эмгэг (F06)	14040	11.7
4	Органик бус нойргүйдэл (F51)	11003	9.1
5	Оюуны хөнгөн хомсдол (F70)	9274	7.7
6	Оюуны хүндэвтэр хомсдол (F71)	8154	6.8
7	Бие хүний органик эмгэг, Энцефалит болон тархины доргилтын дараах хамшинж (F07)	6616	5.5
8	Хүүхдийн аутизм, Хэвшинжит бус аутизм, Хөгжлийн ерөнхий эмгэг, тодорхойгүй (F84)	6169	5.1
9	Шизофрени (F20: бусад, энгийн, үлдэц, өвөрмөц эмнэлзүйгүй, кататоник, хий үзэгдэлт дэмийрлийн хэлбэр)	4185	3.5
10	Стрессийн эмгэг, Дасан зохицохын эмгэг (F43)	3221	2.7
Нийт		98382	81.74

Монгол Улсад 2025 онд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг амбулатори болон стационариар авсан нийт 27908 эмчлүүлэгчийн 11064 буюу 39.6 хувь нь Улаанбаатар хотын, үлдсэн 16844 буюу 60.4 хувь нь 21 аймгийн харьяат байв. Аймагчилсан тархалтыг зураглаж үзвэл (График 1) Дархан-Уул, Ховд, Сэлэнгэ, Баянхонгор, Орхон зэрэг аймаг эхний тавд эрэмбэлэгдэж байгаа нь нэг талаас хүн амын тоотой холбоотой байж болох ч нөгөө талаас сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах хэрэгцээ, шаардлага ихтэй байгаагийн илрэл юм.

График 1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан хүний тоо, 2025



2.2. Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалт

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр болох ЭМДС-гийн гүйцэтгэлд тулгуурлан Монгол Улсын хүн ам дахь сэтгэцийн ба зан төрхийн нийт эмгэгийн тархалтыг тандан судалсан үр дүнг дээр толилуулсан билээ. Солиорол, дэмийрлийн улмаас сэтгэцийн эмч, эмнэлгийн байнгын хяналтад байдаг иргэдээс гадна нийгэм, хамт олны дунд ажил хөдөлмөр эрхэлж, жирийн амьдарч буй иргэдийн дунд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтыг тогтоосноор хүн амынхаа одоогийн сэтгэцийн төлөв байдлыг тандан үнэлж, дүгнэх, цаашдын болзошгүй хүндрэлээс сэргийлэх нийгэм-сэтгэлзүйн олон талт арга хэмжээ, дэмжлэгийг хэрэгжүүлэхэд чухал баримжаа болох ач холбогдолтой.

Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгааг 2013 онд цуглуулсан өгөгдөлд суурилан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (СЭМҮТ)-ийн эмч, судлаачид гүйцэтгэж, тайлангаа 2019 онд хүлээлгэж өгчээ (СЭМҮТ 2019). Үндэсний түвшинд ийм төрлийн судалгаа хийх арга зүйгээ боловсруулж, бэлтгэл хангах, эмнэлзүйн ганцаарчилсан ярилцлага, үзлэгийн аргаар өгөгдөл цуглуулах, боловсруулалт хийж, тайлагнахад ихээхэн цаг хугацаа шаардагддаг байна. Хэрэв эрүүл мэндийн эрт илрүүлгийн багц бүрт “Одоогийн сэтгэцийн төлөв байдлыг тодорхойлох” шинжилгээг багтаавал богино хугацаанд, бага өртөг зардлаар нийгмийн сэтгэлзүй, сэтгэцийн эрүүл мэндийн төлөв байдал, хандлагыг тандах боломж бүрдэх давуу талтай.

СЭМҮТ-ийн хэрэгжүүлсэн дээрх судалгаа нь өнөөгийн байдлаар үндэсний түвшинд хамгийн сүүлд хийсэн, харьцангуй иж бүрэн судалгаа тул гол үр дүнгүүдийг тайлангаас нь шууд эшлэн хүргэж байна. Судалгаанд Монгол орны газарзүйн бүсчлэлийн дагуу Баруун (Ховд, Завхан), Хангай (Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон), Төв (Сэлэнгэ, Дархан-Уул, Дорноговь), Зүүн (Дорнод, Хэнтий) бүсээс нийт 11 аймгийн 53 сум, Улаанбаатар хотоос төвийн 3, алслагдсан 2 дүүргийг санамсаргүй түүврийн аргаар сонгож нийт 12200 хүнийг хамруулжээ. Судалгааны үр дүнгээс авч үзвэл:

- Судалгаанд оролцогч 18-64 насныхны дунд сэтгэл түгших эмгэг 18.4, органик бус нойрны эмгэг 17.5, архаг ядаргаа 16.2, тайлбарлаж боломгүй биеийн зовуурь шаналгаа 11.9, архинд донтох эмгэг 6.4 сэтгэл гутрах эмгэг 6.2 хувийн тархалттай;
- 18-64 насны хүн амын дунд ойролцоогоор таван хүн тутмын нэг нь сэтгэл түгших эмгэгтэй, 5-6 хүн тутмын нэг нь органик бус нойрны эмгэгтэй, зургаан хүн тутмын нэг нь архаг ядаргаатай, найман хүн тутмын нэг нь тайлбарлаж боломгүй биеийн зовуурь шаналгаа эмгэгтэй, 15-16 хүн тутмын нэг нь архинд донтох эмгэгтэй, 16 хүн тутмын нэг нь сэтгэл гутрах эмгэгтэй байх магадлалтай байна.

Дээрх судалгааны дүнг Монгол Улсад 1984-1992 онд хийсэн судалгааны дүнтэй харьцуулахад архаг ядаргаа эмгэг 253.7 дахин, архинд донтох эмгэг 42.7 дахин өссөн үзүүлэлт гарчээ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоо, судалгаагаар дэлхий дахинд хүүхэд, өсвөр насныхны 20 хувь нь сэтгэл хөдлөл, зан үйлийн тулгамдсан асуудалтай байдаг бөгөөд ихэнх сэтгэцийн эмгэг хүүхдийн өсвөр насанд илэрдэг (Баярмаа 2017). Монгол Улсын сэтгэцийн эрүүл мэндийн тогтолцоог 2005 онд үнэлээд “Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үгүйлэгдэж байна” гэж тэмдэглэснийг анхааран үзэж өсвөр насанд түгээмэл тохиолддог сэтгэл хөдлөл, зан үйлийн судалгааг Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-д суурилан сэтгэцийн тулгамдсан асуудлыг эрт илрүүлэх, эмгэг үүсэх болон эмгэг зан үйлтэй бие хүн бий болохоос сэргийлэх зорилгоор хот, хөдөөгийн ЕБС-д суралцаж буй 11-18 насны 2250 хүүхдийг хамруулсан судалгаа хийсэн байна (Баярмаа 2017). Уг судалгаанд оролцогсод өсвөр насанд түгээмэл тохиолддог сэтгэл хөдлөл, төрх үйл, анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх байдал, үе тэнгийнхний харилцаа, нийтэч зан үйл гэсэн таван илрэлийг судлахад өсвөр насанд илэрдэг сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгийн дундаж тархалт 8.95 хувь байв.

Ийнхүү Монгол Улсын хүн амын өсвөр насны хүүхдүүд болон 18-64 насныхны дунд хийсэн судалгааны үр дүнгээс үзвэл хүн ам дахь зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалт үлэмж анхаарал татах түвшинд хүрсэн нь тодорхой байна.

Гурав. Сэтгэцийн ба зан төрхийн эмгэгийн оношоор ангилсан тархалт

Монгол Улсын хүн амд 2025 онд Өвчний олон улсын Х ангиллын F00-F99 кодтой 100 оношоос 72 нь бүртгэгдсэн байна (Хүснэгт 3). Өөрөөр хэлбэл: Олон улсад бүртгэлтэй нийт 100 төрлийн сэтгэцийн эмгэгийн 72 нь манай улсын хүн амд тохиолдож байна гэсэн үг.

Хүснэгт 3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан хүний тоо, санхүүжилт, 2025

№	Сэтгэцийн ба зан төрхийн эмгэг, код	Эмчлүүлсэн хүний тоо	Өвчлөлд эзлэх хувь	ЭМДС-гаас олгосон санхүүжилт
1	Архины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг (F10)	3703	13.3	8,078,880,385.0
2	Тархины гэмтэл ба үйл ажиллагааны хямрал, бие махбодын өвчний шалтгаант сэтгэцийн бусад эмгэг (F06)	2568	9.2	5,003,081,298.0
3	Мэдрэл сульдал (F48)	2556	9.2	5,273,360,666.0
4	Оюуны хөнгөн хомсдол (F70)	2459	8.8	4,267,283,488.0
5	Оюуны хүндэвтэр хомсдол (F71)	2282	8.2	2,643,999,243.0
6	Бие хүний органик эмгэг, Энцефалит болон тархины доргилтын дараах хамшинж (F07)	1767	6.3	2,087,374,919.0
7	Шизофрени (F20: бусад, энгийн, үлдэц, өвөрмөц эмнэлзүйгүй, кататоник, хий үзэгдэлт дэмийрлийн хэлбэр)	1526	5.5	4,213,414,587.0
8	Органик бус нойргүйдэл (F51)	1400	5.0	2,324,462,756.0

9	Шизоаффектив эмгэг (F25)	1024	3.7	2,508,572,287.0
10	Стрессийн эмгэг, Дасан зохицохын эмгэг (F43)	865	3.1	879,167,407.0
11	Сэтгэл түгших түгмэл эмгэг, Сэтгэл түгших ба сэтгэл гутрах холимог эмгэг (F41)	836	3.0	951,948,315.0
12	Оюуны хүнд хомсдол (F72)	782	2.8	316,161,733.0
13	Хүүхдийн аутизм, Хэвшинжит бус аутизм, Хөгжлийн ерөнхий эмгэг, тодорхойгүй (F84)	632	2.3	271,587,591.0
14	Хоёр туйлт сэтгэл цочирдлын эмгэг (F31)	600	2.1	871,934,150.0
15	Сэтгэл гутрах тохиол (F32)	556	2.0	585,562,955.0
16	Түр зуурын тик, Хөдөлгөөний ба дуу авианы архаг тик, Дуу авианы ба олон янзын хөдөлгөөн хосолсон тик [Тоуреттегийн хамшинж], Тик, тодорхойгүй (F95)	405	1.5	119,883,387.0
17	Сэтгэл гутрах дахилтат эмгэг (F33)	366	1.3	340,917,754.0
18	Шизофрени төст, Шизофренийн шинж тэмдэг бүхий болон Шизофренийн шинж тэмдэггүй цочмог солиорох эмгэг (F23)	289	1.0	640,123,794.0
19	Судасны өвчний гаралтай тэнэгрэл, тодорхойгүй (F01)	266	1.0	36,444,195.0
20	Биешсэн эмгэг, Биеийн хэлбэрийн өвөрмөц эмнэлзүйгүй эмгэг, Өвчирхөх эмгэг (F45)	242	0.9	62,192,938.0
21	Өөр бүлэгт ангилсан тодорхой өвчний үеийн тэнэгрэл (F02)	201	0.7	54,302,278.0
22	Хэл ярианы хөгжлийн эмгэг (F80)	197	0.7	70,272,343.0
23	Тамхины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг (F17)	183	0.7	133,747,717.0
24	Бие хүний сэтгэлийн хөдөлгөөн тогтворгүй болох эмгэг, Бие хүний истерийн болон шизоид эмгэг (F60)	178	0.6	155,427,892.0
25	Гэр бүлийн хүрээгээр хязгаарлагдсан зан төрхийн эмгэг, Зан төрхийн нийгэмшсэн эмгэг, Зан төрхийн нийгэмшилгүй эмгэг, Зан төрхийн эмгэг, тодорхойгүй (F91)	169	0.6	97,087,438.0
26	Органик бус солиорол, тодорхойгүй (F29)	161	0.6	65,791,839.0
27	Идэвх ба анхаарлын хямрал, Зан төрхийн хэт идэвхжилийн эмгэг (F90)	143	0.5	25,466,493.0
28	Органик бус шээс задгайрах эмгэг, Органик бус өтгөн задгайрах эмгэг, Ээрэх, Хүүхэд ба өсвөр насанд зонхилон илэрдэг зан төрхийн ба сэтгэл хөдлөлийн тодорхой эмгэгүүд (F98)	138	0.5	30,641,840.0
29	Диссоциатив эмгэг (F44)	126	0.5	56,335,749.0
30	Олон төрлийн сэтгэц идэвхт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэц болон зан төрхийн эмгэг (F19)	106	0.4	121,918,957.0
31	Үл ялих зовлонт үзэгдэл (F42)	101	0.4	35,753,005.0
32	Солиорох шинж бүхий болон Солиорох шинж тэмдэггүй сэтгэл хөөрөл (F30)	99	0.4	89,112,087.0

33	Дуудлагын өвөрмөц эмгэг, Сургуулийн дадлын хөгжлийн эмгэг (F81)	96	0.3	33,849,510.0
34	Оюуны маш гүнзгий хомсдол (F73)	88	0.3	19,863,788.0
35	Альдхаймерын өвчний тэнэгрэл, тодорхойгүй (G30.9+), F00	81	0.3	11,093,878.0
36	Шизофренийн хэвшинжит эмгэг (F21)	80	0.3	75,498,078.0
37	Айдас, Айдаст сэтгэл түгших эмгэг, тодорхойгүй (F40)	73	0.3	15,854,347.0
38	Мөрийцөх дон, Бусад зуршилт ба импульсив эмгэг (F63)	66	0.2	114,601,725.0
39	Дэмийрэх эмгэг (F22)	62	0.2	48,401,656.0
40	Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг (F13)	49	0.2	21,108,981.0
41	Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэг. Бусад сэтгэцийн ба зан төрхийн эмгэг (F18)	47	0.2	42,024,249.0
42	Зан төрхийн сэтгэл гутрах эмгэг, Зан төрхийн ба сэтгэл хөдлөлийн холимог бусад эмгэг (F92)	47	0.2	48,511,632.0
43	Хүүхдийн сэтгэл түгшин айх эмгэг, Хүүхдийн сэтгэл хөдлөлийн бусад эмгэг (F93)	43	0.2	4,789,559.0
44	Өөр бүлэгт ангилаагүй төрсний дараах сэтгэцийн болон зан төрхийн хүнд эмгэгүүд (F53)	37	0.1	14,448,625.0
45	Хоол идэх дурын эмгэг, тодорхойгүй (F50)	34	0.1	2,352,418.0
46	Оюуны хөгжлийн бусад хомсдол (F78)	29	0.1	1,372,244.0
47	Оюуны хомсдол, тодорхойгүй (F79)	25	0.1	1,158,941.0
48	Хар тамхины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг (F11)	22	0.1	9,261,891.0
49	Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг (F12)	20	0.1	11,707,600.0
50	Бусад сэдээгч хэрэглэснээс үүссэн сэтгэцийн болон зан төрхийн эмгэг (F15)	16	0.1	10,034,114.0
51	Сонгомол дуугүйрэл, Хүүхдийн нийгмийн үйл ажиллагааны бусад эмгэг (F94)	11	0.0	393,772.0
52	Тэнэгрэл, тодорхойгүй (F03)	9	0.0	486,941.0
53	Сэтгэл цочирдох эмгэг, тодорхойгүй (F39)	8	0.0	443,295.0
54	Тэнэгрэлийн суурин дээр бий болсон дэмийрэл (F05)	5	0.0	405,838.0
55	Архины болон бусад сэтгэц идэвхт бодисоос үүсээгүй органик ойгүйдлийн хамшинж (F04)	4	0.0	157,315.0
56	Сэтгэцийн органик болон шинж тэмдгийн эмгэг, тодорхойгүй (F09)	3	0.0	63,760.0
57	Байнга сэтгэл цочирдох эмгэгүүд (F34)	3	0.0	87,332.0
58	Бэлгийн дур буурах буюу үгүй болох эмгэг (F52)	3	0.0	115,170.0
59	Трансексуализм (F64)	3	0.0	436,600.0

60	Сэтгэлзүйн хөгжлийн өвөрмөц холимог эмгэгүүд (F83)	3	0.0	110,558.0
61	Сэтгэлзүйн хөгжлийн эмгэг, тодорхойгүй (F89)	3	0.0	74,504.0
62	Хараат байдал үл үүсгэх бодисыг хэтрүүлэн хэрэглэх (F55)	2	0.0	78,332.0
63	Бусад органик бус солиорох эмгэг (F28)	1	0.0	32,000.0
64	Сэтгэл цочирдох бусад эмгэг (F38)	1	0.0	45,360.0
65	Өөр бүлэгт ангилсан өвчин эмгэгтэй холбоотой сэтгэлзүйн болон зан төрхийн хүчин зүйлс (F54)	1	0.0	46,720.0
66	Бие хүний холимог ба бусад эмгэг (F61)	1	0.0	44,226.0
67	Тархины гэмтэл ба өвчинтэй холбоогүй бие хүний тогтонги өөрчлөлтүүд (F62)	1	0.0	70,200.0
68	Бэлгийн бойжлын эмгэг (F66)	1	0.0	41,200.0
69	Насанд хүрэгчдийн бие хүний ба зан төрхийн бусад эмгэг (F68)	1	0.0	32,000.0
70	Хөдөлгөөний үйлийн хөгжлийн өвөрмөц эмгэгүүд (F82)	1	0.0	41,200.0
71	Сэтгэлзүйн хөгжлийн бусад эмгэг (F88)	1	0.0	44,226.0
72	Насанд хүрэгчдийн бие хүний ба зан төрхийн бусад эмгэг (F99)	1	0.0	22,680.0
	Нийт	27908	100.0	42,901.417.951.0

Дээрх хүснэгтэд харуулсан тухайн эмгэгээр эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан хүний тоо, өвчлөлд эзлэх хувь болон эмчилгээний зардалд зориулж ЭМДС-гаас олгосон мөнгөн дүнд үндэслэн дараах хэдэн зүйлийг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм. Үүнд:

- 72 төрлийн эмгэгийг эмчлүүлэгчийн тоон дүнгээр нь эрэмбэлж үзвэл Архины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг (F10) хамгийн олон буюу 3703 байгаа ба нийт өвчлөл²-ийн 13.3 хувийг эзэлж байна. F10 эмгэгийн эмчилгээнд зориулж ЭМДС-гаас найман тэрбум гаруй төгрөг зарцуулсан нь сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тухайн жилд олгосон нийт санхүүжилтийн 18.8 хувьтай тэнцэж байгаа юм.
- Тархины гэмтэл болон үйл ажиллагааны хямралаас шалтгаалсан сэтгэцийн эмгэг, мэдрэл сульдал тус бүр 9.2 хувийг эзэлж хоёрдугаарт бичигдсэн бол органик бус нойргүйдэл 5.0, стрессийн эмгэг 3.1, сэтгэл түгших эмгэг 3.0, сэтгэл гутрах тохиол 2.0, сэтгэл гутрах дахилтат эмгэг 1.3 хувиар удаах байруудыг эзэлж байна. Ихэвчлэн нийгмийн хүчин зүйлс, нөлөөгөөр үүсдэг эдгээр эмгэг нийлбэр дүнгээрээ нийт өвчлөлийн 23.6 хувийг эзэлж буйг онцгой анхаарвал зохилтой.

² Сэтгэцийн ба зан төрхийн эмгэгээр

- Оюуны хомсдолын бүхий л хэлбэрээр 2025 онд 4883 иргэн эмнэлэгт хандсан нь нийт өвчлөлийн 18.4 хувийг эзэлж байна. “Оюуны хомсдол” оноштой хүн эмнэлгийн өдөр тутмын эсвэл яаралтай тусламж, үйлчилгээ авах шаардлага бага байдаг тул 2025 онд энэ эмгэгээр эмнэлэгт хандсан давтамж нь бодит тооноос хавьгүй цөөн байна.
- Шизофрени, шизоаффектив эмгэг болон шизофрени төст эмгэгийн тархалт нийт өвчлөлийн 10.2 хувийг эзэлж байна.
- Хүүхдийн аутизм 13 дугаарт эрэмбэлэгдэж, нийт өвчлөлийн 2.3 хувийг эзэлж байна.

Дүгнэлт

1. Монгол Улсад 2025 онд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан иргэдийн дунд сэтгэцийн 72 төрлийн эмгэг бүртгэгдсэн нь хүн амын сэтгэцийн эмгэгт өртөх байдал өргөн хүрээнд байгааг илтгэнэ.
2. Архины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг хамгийн өндөр хувьтай тохиолдож, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олгосон ЭМДС-гийн санхүүжилтийн 18.8 хувийг дангаараа эзэлж буйгаас үзвэл архи дан согтуурах үзэгдэл даамжирч, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд томоохон ачаалал, дарамт үүсгэж байна.
3. Стресс, түгшүүр, нойргүйдэл, сэтгэл гутрал зэрэг ажил, амьдралын хэв маяг, нийгмийн шалтгаантай эмгэгүүд харьцангуй өндөр хувийг эзэлж байгааг улс орны нийгэм-эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, ахуй амьдралын орчин, сэтгэлзүйн дарамт, нийгмийн бухимдал, стресс зэрэг хүчин зүйл монголчуудын сэтгэцийн эрүүл мэндэд хүчтэй нөлөөлж байгаагийн илрэл гэж үзүүштэй.
4. Хүүхдийн аутизмын тохиолдол ихсэж байгаа нь нэг талаас хөгжлийн эмгэгийн илрүүлэг сайжирч байгаатай холбоотой байж болох ч нөгөө талаас аутизмын тархалт бодитой нэмэгдэж, хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ цаашид өсөх хандлагатай илтгэж байна.
5. Өсвөр насныхны дунд сэтгэл хөдлөл, төрх үйлийн эмгэг багагүй тархсан, “Эдийн засгийн идэвхтэй хүн ам” буюу 18-64 насныхны 5-16 хүн тутмын нэг нь зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгтэй байгаа нь нэн харамсалтай бөгөөд нийт хүн амын эрүүл мэндийг сууриар нь сайжруулах бодлого, арга хэмжээ үгүйлэгдэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

Bayasgalan, B., Matsumoto, T., Altangerel, O. 2018. “(2018). On-board measurement and emission prediction from vehicle engines using ordinary fuel and fuel additives in Mongolia.” Journal of JSCE (Japan Society of Civil Engineers) (6): 118–126.

Enkhmaa, E., Batsuuri J, Lkhagvasuren Ts. 2010. “Relationship between geographical distributions of population morbidity and climatic extremes in Mongolia.” Journal of Health Sciences 30-34.

World Health Organization. 1946. Constitution of the World Health Organization. New York, July 22.

Баярмаа, В. 2017. Өсвөр насныхны сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгийн зарим асуудалд. Анагаах Ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар.

МХЕГ, (Мэргэжлийн хяналтын ерөнхий газар). 2019. ОХУ-ын лабораторид шинжлүүлсэн сайжруулсан түлш стандартын шаардлага хангаж байна. 10 25. <http://home.inspection.gov.mn/news/295/single/1975>.

СЭМҮТ. 2019. Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалт. Улаанбаатар: Тоонот принт.

Энхмаа, Э., Батсуурь, Ж. 2016. Монгол хүний эрүүл мэндэд уур амьсгалын хахиршилтын нөлөө. Стратегийн судалгаа 74: 27-31.

Эрдэнэбаяр, Л. 2012. Сэтгэц судлал. Улаанбаатар: Сэлэнгэпресс ХХК.

Current Situation and Outlook of Mental Health of the Mongolian Population

Enkhmaa Erdene-Ochir

Doctor (Ph.D), Associate professor, Senior Research Fellow, enkhmaa@iss.gov.mn
The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Abstract

This article presents the results of a study analyzing data on patients in Mongolia who received outpatient and inpatient care with diagnoses of mental disorders (F00-F99) over the past four years. Between 2022 and 2024, a total of 79,861 individuals received mental health services 347,674 times, averaging 26,620 individuals and 115,891 cases per year. In 2025, this number increased to 27,908 individuals and 120,355 cases.

When the 27,908 patients who received medical care in 2025 were ranked by diagnostic frequency, alcohol-related disorders (F10) were the most common. These were followed by other mental disorders due to brain damage and dysfunction and to physical disease (F06), neurasthenia (F48), mild mental retardation (F70), moderate mental retardation (F71), personality and behavioural disorders due to brain disease, damage and dysfunction (F07), schizophrenia (F20), non-organic sleep disorders (F51), schizoaffective disorder (F25), and reaction to severe stress, and adjustment disorders (F43).

Meanwhile, a study conducted by the National Center for Mental Health titled “Prevalence of Common Mental Disorders” found that among Mongolia’s population aged 18-64, anxiety disorders had a prevalence of 18.4%, non-organic sleep disorders 17.5%, chronic fatigue 16.2%, medically unexplained physical symptoms 11.9%, alcohol dependence 6.4%, and depressive disorders 6.2%.

Keywords: *mental disorders, alcohol dependence, neurasthenia, insomnia, mental retardation*